



**ХЭНГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 5/07

Хэрлэн сум

**Г.Пүрэвбаатарт хувийн
чөлөө олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтэн Галсанчүлтэмийн Пүрэвбаатарын гаргасан хүсэлтийн дагуу 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хувийн чөлөө олгосугай.

2.Хувийн чөлөөтэй байх хугацааны олговрыг олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНТУЛГА